
 БАТЛАВ
 ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 С.ЭНХБАЯР
 2023 оны 10 дугаар сарын ... өдөр

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ
ДЭЭВЭР ЗАСВАРЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР**

2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Ажлын цар хэмжээ:

Энэхүү ажил нь иргэдэд аюулгүй, тохилог орчинд амьдрах, ажиллах таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

Нийтийн зориулалттай орон сууцны засварын ажлыг хийж гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах.


1	Төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр тогтоол.
2	Байршил, барилгын хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо 42 дугаар байр 900 м.кв. - Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо 27/1 дүгээр байр 450 м.кв, 86, 88 дугаар байр тус бүр 900 м.кв, 96 дугаар байр 700 м.кв, - Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо 49 дүгээр байр 1350 м.кв. - Хан-Уул дүүргийн 25 дугаар хороо 703, 706, 714, 715, 719, 722, 725, 726, 727 дугаар байр тус бүр 460 м.кв.
3	Зориулалт хүчин чадал	<ul style="list-style-type: none"> - Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар. - Гүйцэтгэгч байгууллага зургийн шатанд илүү дэлгэрэнгүй талбайн судалгаа, хэмжилтийг хийж нарийвчлах.
4	Одоогийн байдал	<ul style="list-style-type: none"> - Орон сууцны барилгын дээврийн хамгаалалтын хар цаасан давхарга нь парапетан хана болон нийт хэсгүүдэд хөндийрч, хучилтанд зай засвар, хагарал үүссэн. - Төмөр дээврийн хийцлэл зэвэрч муудсан.
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
7	Төсөл гүйцэтгэх байгууллага	- Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг,

		төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, угсралт засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой.
8	Төсөл гүйцэтгэх үе шат	<ul style="list-style-type: none"> - Талбайн судалгаа, хэмжилт хийх. - Хорооны Засаг дарга болон СӨХ-той заавал зөвшилцсөний дараа ажлын тоо хэмжээг захиалагчид танилцуулах. - Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. /магадлал хийгдсэн байх/. - Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/. - Батлагдсан зураг төсөвийн дагуу дээвэр засварын ажил гүйцэтгэх.
9	Төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Одоо байгаа хавтгай дээвэр болон шувуун нуруун дээврийг буулгалтын ажлын технологи, өндрийн хөдөлмөр хамгааллыг баримтлан, бүрэн буулгаж, талбайг цэвэрлэн дараагийн үе шатанд бэлтгэх. - Тухайн ажлын талбайн онцлогт нийцүүлэн цутгамал болон шувуун нуруун дээврийн ажлыг БНБД, MNS норм, стандартуудыг баримтлан төлөвлөх. - Дээврийн ус зайлуулах хоолойн ажиллагааг шалгаж нягтлан шаардлагатай арга хэмжээг авах. - Дээврийн агааржуулах хоолой, бохирын яндан хоолойд малгайвч төмөр угсрах. - Бусад дээврийн хийц болон дээврийн орон зайд хамрагдах зайлшгүй хийгдэх ажил байгаа эсэхийг нягтлан шалгаж ажлын зураг боловсруулан тоо хэмжээ гаргах.
10	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Монгол Улсын хуулиуд</u></p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль - Барилгын тухай хууль - Бусад холбогдох хууль <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Дээврийн хучилт /БНбд31-02-03/ - Дээврийн ажил /БНбд31-07-05/ - БД 31-108-08 - Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05 - БД 23-103-10 Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт - MNS 3154-1981 40мм хүртэл диаметртэй арматуран гагнасан тор. Ерөнхий техникийн шаардлага - MNS 6303:2016 Дээвэр болон барилга байгууламжид хэрэглэх ус, уур тусгаарлах хуйлмал материал.Техникийн ерөнхий шаардлага - Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Бусад холбогдох норм, дүрэм
11	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Орон сууцны барилгын дээвэр дээр байгаа холбоо, цахилгааны кабелийг цэгцлэх.


		- Байрилгын ус зайлууллах хоолойг шинэчлэн засварлах.
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.
13	Онцгой нөхцөл	- Дээврийн засварын ажилд хэрэглэгдэх материалууд нь бүгд гарал үүслийн гэрчилгээтэй, барилгын материалын лабораториар баталгаажсан сертификаттай, Монгол улс болон олон улсын чанар стандартын шаардлагыг бүрэн хангасан байх. - Засварын ажилд хэрэглэгдэх машин механизмын аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах - Өндөрт ажиллах ХАБЭА-н дүрэм, журмыг чанд мөрдөх.

- Зураг төсвийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалтыг өөрчлөхгүйгээр төсөвт өртөгт багтаах. Төсөвт өртөг хэтэрсэн тохиолдолд ажлын зураг батлагдахгүй болно.

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  О.МӨНГӨНШАГАЙ